

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 17/457

ШУС, НУС

2016

**СЭТГҮҮЛЧ Г.ОДГАРАВЫН “НИЙСЛЭЛИЙН ТӨВ ЦЭВЭРЛЭХ
БАЙГУУЛАМЖ” ЦУВРАЛ СУРВАЛЖЛАГЫН ШҮҮМЖ**

Б.Наранбаатар *

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D)

Түлхүүр үг: мэдээллийн портал сайт, цуврал сурвалжлага, Төв цэвэрлэх байгууламж, сэтгүүлч Г.Одгарав, gogo.mn, нийтлэлийн үр дүн, интернет сэтгүүл зүй, нийтлэлийн мультимедиа шинж, сэтгүүлчийн ур чадвар

Үндэсний тэргүүлэгч мэдээллийн сайт GoGo.mn-ы сэтгүүлч Г.Одгарав нь 2015 оны 6 дугаар сараас эхлэн Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, хүчин чадал, түүнээс үүдсэн нийгмийн асуудлууд, уг байгууллагын ажилчдын нийгмийн асуудал зэргийг хөндсөн цуврал сурвалжлага, ярилцлага бэлтгэн уншигчдад хүргэж, өнөөг хүртэл (2015.12.02) энэ сэдвээ орхилгүй (сүүлийн материал нь 11.30-д нийтлэгдсэн) тууштай сурвалжилсаар байгаа юм.

2015 оны зургаадугаар сарын эхээр нийслэлийн Төв цэвэрлэх байгууламжийн засварын ажил сунжирснаас үүдэн Улаанбаатар хотын иргэдийг олон хоног бухимдуулсан таагүй үнэрийн мөрөөр, учир шалтгааныг тодруулахаар сэтгүүлч Г.Одгарав уг байгууллагад очжээ. Гэтэл энэ нь түүний хувьд олон цуврал нийтлэ-

лээрээ сэтгүүлчийн ур чадвараа уншигчдад төдийгүй мэргэжлийн хүрээнд үнэлэгдэх, иргэний үүргээ биелүүлж, нийтлэлийнхээ тодорхой үр дүнг харах, мөн мэдээллийн сайтын 2015 оны шилдэг сэтгүүлчээр нэрлэгдэх боломжийг олгож, нөр их хөдөлмөр, зүтгэлийнх нь урт замын эхлэл болсон байна.

Сэтгүүлч Г.Одгарав нь “Төв цэвэрлэх байгууламж” цуврал нийтлэлийн хүрээнд нийслэлийн цэвэр усны хэрэглээ, бохир усны асуудлыг хөндөж, сэдвийн дагуу бүх талын эх сурвалж, байр суурийг багтаасан, асуудалд олон талаас нь хандаж, бодитой шийдэл хайхад чиглэсэн сурвалжлагуудыг бэлтгэн нийт 20-иод тооны материал нийтлүүлжээ. Сэтгүүлч сонгосон сэдвээ ул суурьтай хандаж, бохир ус, эвгүй үнэрийн асуудлыг зөвхөн Төв цэвэрлэх байгууламжийн ачаалалтай холбон орхих бус, харин түүний үр дагавар, дам нөлөөлөл, нийгэм, эрүүл мэндийн талыг олж харан сурвалжилж байсан нь цуврал нийтлэлийг сонирхолтой, үр дүнтэй болоход нөлөөлжээ. Асуудалд тууштай хандан, олон нийтийг хамарсан мэдээллийн тренд болох хүртэл нь авч явж чадсан нь Г.Одгаравын ур

чадвар, сэтгүүлчийн хариуцлагатай байдлыг илтгэх нэгэн зүйл болно. Мөн Г.Одгаравын нийтлэл, сурвалжлагуудад GoGo.mn сайтын, ер нь цахим сэтгүүл зүйн технологийн оновчтой шийдлүүдийг ашиглан, фото, инфографик, видео, текст, санал асуулга, график зураг зэргээр баяжуулан, мультимедиа хэлбэрээр уншигчдад хүрч, нийгмийн сүлжээ сайтуудаар түгээж байсан нь төр, олон нийтийн анхаарлыг татах хүчин зүйл болжээ.

Одгаравын цуврал сурвалжлагын үр дүнд нийслэлийн ■ бохир усны асуудал, Туул голын бохирдол, түүний үр дагавар, цаашдын эрсдэл, Төв цэвэрлэх байгууламжийн технологи шинэчлэлийн шаардлага, төрийн субъектуудын түүнд чиглэсэн үйл ажиллагаа зэргийн талаар цогц мэдээлэл олон нийтэд хүрч, тодорхой бодит үр дүн гарч байгаа нь сэтгүүлчийн нийгмийн хариуцлагын тод жишээ болж буйг онцлоход таатай байна.

Г.Одгаравын хөндсөн сэдэв, хүрсэн үр дүнг дараах байдлаар багцалъя. Үүнд:

- Нийслэл хотын Төв цэвэрлэх байгууламж хүчин чадал хүрэлцэхгүй, өнөөгийн ачааллыг даах техник, технологийн шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай байгааг илрүүлэн шийдвэр гаргах түвшинд нөлөө үзүүлж, өдгөө Засгийн газрын зохих субъектуудын бодлого үйл ажиллагаанд тусаад явж байна.

- Төв цэвэрлэх байгууламжийн ажилчдын хөдөлмөр хамгаалал, нийгмийн асуудлыг хөндөн тавьснаар тэдний эрх ашгийг хамгаалсан олон шийдвэр гарсан. /тэтгэвэр, эрүүл мэнд, цалин, хөдөлмөрийн нөхцлийн нэмэгдэл, хангалт г.м./

- Нийслэлийн цэвэрлэх байгууламжийн ачааллаас үүдэн Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэр болсон Туул гол экологийн асуудалтай тулгарсныг олон талаас нотлон нийгэм, ХМХ, иргэдийн анхаарлыг татаж мэдээллийн тренд болж чадсан.

- Туул голын экологийн байдал нь цаашлаад нийслэлийн агаар, хөрс, ундны усны бохирдол, нийслэл орчмын газар нутаг, мал, малчдын хохирол, ирээдүйн эрсдэлийг дагуулж буйг олон нийтийн сонорт хүргэсэн зэрэг болно.

Сэтгүүлч Г.Одгаравын сонгож авсан сэдэв нь л оновчтой, цагаа олсон, олон нийтийн эрх ашигт нийцсэн байсан гэвэл өрөөсгөл болно. Түүний сонирхолтой, уншигчийг “дуудсан” гарчгууд; (“Сайд ирэхгүй ээ, харж л байгаарай”¹, “Алтанбулагт нэг нүдтэй хурга бус хүн мэндэлвэл хариуцлагыг нь хэн үүрэх вэ?”², “Цэвэрлэх байгууламж шинээр барьтал махнаас гарцгаая!”³, “Тэтгэвэрт гарч амжилгүй өөд болсоор байгаа нь хортой гэж тодорхойлох хангалттай шалтгаан биш үү”⁴ г.м.), нүд сэтгэлд буутал дүрслэх зураглалууд; (“...Хааяахан хавирга нэвт салхилах энэ өглөө хотын баруун захын урдхан хэсэгт уур цан цохиж орчмын барилга байгууламж өдрийн наран хөөртөл үл харагдана. Захын модод цан дааж эгээ л цасаар урласан аятай цайрна. Тэндээс өмхий үнэр ханхлах авч зуныхаас бага цоргино. Энэ үнэрийг үл ажирсан ажлын хувцастай хүмүүс хаашаа ч юм бэ яаран алхана...”⁵, “...Хотод амар амгалан ноёлж хүн бүхэн дуг нойрондоо дугжирч байх энэ цаг үед насосны дуу өдөр шөнөөс үл хамаарч тасралтгүй хангинана. Жихүүдэс хүрэм хүйтэн, хөгцөндөө баригдан чийг даасан, он жилийг

удаан элээсэн мэт балгасжсан, ялгадасны эхүүн үнэр нэвчсэн энэ барилга насосны дуунд дөжрөөд 30 орчим жилийн нүүрийг үзжээ. Албан ёсны тодорхойлолтоор уг барилгыг “Шинэ захын насос станц” гэх боловч тэндэхийн ажилчид “сараалж” хэмээн хочилно...⁶).

Мөн үнэхээр л шийдэлд хүрчих юмсан, ТЦБ-ын ажилчдад туслах юмсан, нийслэлийн бох ир ус, Туул голын экологийн асуудлыг шийдэхэд хувь нэмрээ оруулах юмсан гэсэн сэтгүүлчийн чин хүсэл амжилтын түлхүүр нь болжээ.

Мультимедиа хэрэгсэл, боломжийг чадварлаг ашиглан, бичлэг, ур чадварын хувьд өсч яваа залуу сэтгүүлч бүсгүйн цаашдын бүтээл, хөдөлмөрт тустай болов уу гэх үүднээс шүүмж бичигчийн хувиар хэдэн санааг тэмдэглэе.

1. Төв цэвэрлэх байгууламжид хийсэн цуврал сурвалжлагын явцад ажил үүргээ гүйцэтгэж яваа хүмүүсээс ярилцлага авч, тэдний хөдөлмөрийн нөхцөл, хангамж, цалин нэмэгдэл, нийгэм, эрүүл мэндийн асуудлыг тодруулан гаргажээ. Ингэхдээ эх сурвалж болгосноос дэлгэрэнгүй яриа видео хэлбэрээр авч, сайтад нийтлэхдээ текст, видео зэрэгцүүлэн олон яриаг цуг нь тавьжээ. Угтаа бол санал бодлоо илэрхийлж буй бүх хүнийг сонсоод, нэг юмуу хоёр дүр сонгож аваад, тэдний түүх, тохиолдлоор дамжуулан агуулгаа хүргэвэл илүү

оновчтой, товч болно. Агуулга давхцаж буй текст, видео хоёрыг зэрэгцүүлэн тавих нь тийм ч оновчтой сонголт биш юм. Хүн бүхний дуу хоолойг олонд хүргэх гэсэн хүсэлдээ хэт их автах нь дэмий их хөдөлмөр зарцуулахад хүргэдэг. Нэг газар ажиллаж буй хүмүүс нэг ижил асуудал ярих нь элбэг. Иймд агуулгын давхцал ихдүүлэх эрсдэлтэй юм.

2. “Сайд ирэхгүй ээ, харж л байгаарай”⁷ нийтлэлийн гарчиг нь сурвалжлагын үеэр хэн нэгэн эх сурвалжийн хэлсэн үг мэт томъёологдсон байна. Гэтэл яг нийтлэл дэх эх сурвалжуудын ярианд ийм үг, өгүүлбэр гараагүй бөгөөд сэтгүүлч сурвалжлагын төгсгөл ажилчдын хандлагыг ийнхүү болзмол хэлбэрээр тодор-

хойлж буйгаа илэрхийлж байна. Энэ нь сэтгүүлчийг баримт, фактыг зохиож буй мэт сэтгэгдэл төрүүлэх эрсдэлтэй юм. Түүгээр ч зогсохгүй, иймэрхүү болзмол жишээнээс үүдэн хуулийн эсвэл ёс зүйн хариуцлагад татагдсан сэтгүүлчдийн жишээ бий тул цаашид анхаарах хэрэгтэй биз ээ.

3. Туул голын усны бохирдол нь зөвхөн нийслэлийн бус голын ай савд багтах Төв аймгийн хэд хэдэн сумын мал аж ахуй, эрүүл мэнд, экологийн асуудал мөн болохыг Г.Одгарав Алтанбулаг суманд хийсэн цуврал сурвалжлагаар хүргэсэн байна. Асуудалд хандаж буй өнцөг, сэтгүүлчийн чин эрмэлзэл зорилгоо зөвтгөж байгаа

«

Агуулга давхцаж буй текст, видео хоёрыг зэрэгцүүлэн тавих нь тийм ч оновчтой сонголт биш юм. Хүн бүхний дуу хоолойг олонд хүргэх гэсэн хүсэлдээ хэт их автах нь дэмий их хөдөлмөр зарцуулахад хүргэдэг. Нэг газар ажиллаж буй хүмүүс нэг ижил асуудал ярих нь элбэг. Иймд агуулгын давхцал ихдүүлэх эрсдэлтэй юм

»

боловч мэр сэр алдаа гарсныг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, Алтанбулаг суманд оршин суудаг малчдын эрүүл мэнд, малын өвчлөлийн шалтгаан нь Туул голын бохирдолтой шууд холбоотой гэж урьдчлан таамагласан сэтгүүлчийн байр суурь цуврал нийтлэлд нэвт “шингэжээ”. Малчдад тавьж буй асуулт, мэргэжилтэн эсвэл сумын төрийн албан хаагчдаас авч буй тодруулга нь чухам үүнд чиглэж, нотлохыг оролдож буй боловч бодит фактаар баталгаажихгүй байгаа нь сэтгүүлчийн төдийгүй уншигчийн урмыг хугалж байна. Иймд урьдчилсан том дүгнэлт, гаргалгаагаар нийтлэл, сурвалжлагын нийт агуулгыг “чирч” явах нь эцэстээ хий сүржигнэсэн дүр зураг бий болгох эрсдэлтэй. Хэдийгээр бодит байдал дээр сэтгүүлчийн зөв байж болох ч нотлогдохгүй бол агуулгаа “зөөллөж” сурах нь бас нэг чадвар юм.

4. “Цэвэрлэх байгууламж шинээр барьтал махнаас гарцгаая!”⁸ нийтлэлд сэтгүүлч Г.Одгарав удаан хугацаанд бичиж, бодож явсан сэдвийнхээ “фанат” болж эхэлж буй дүр зургийг харж болно. Нэг сэдэв чиглэлээр дагнан бичдэг сэтгүүлчдэд энэ бол байдаг л “мэргэжлийн өвчин”. Асуудал бүрийг өөрийн сэдэвтэй холбон тайлбарлах, зарим талаар дэгсдүүлэх хандлага гарч эхлэхийг би ийнхүү нэрлэлээ. Уг нийтлэл дэх санааг би логик дарааллаар нь томъёолон харуулья. Нийслэлийн иргэд хүнсний махаа Төв аймгаас авдаг. Тэр мах нь эрсдэлтэй, өвчлөлтэй. Төв аймгийн Алтанбулаг болон бусад суманд малын өвчлөл гарч буй нь Туул голын бохирдлоос үүдэлтэй. Туулын бохирдол Төв цэвэрлэх байгууламжийн хаягдлаас үүдэлтэй. Нийслэлийн иргэд

хэрэглэж буй махнаас хордох боломжтой. Иймд энэ Үндэсний аюулгүй байдлын асуудал... хэмээн Г.Одгарав зураглажээ. Малыг бөөрний өвчнийг Үндэсний аюулгүй байдлын асуудал болтол нь томруулж харна, бичнэ гэдэг нь сэтгүүлч өөрийгөө жаахан “тормос”-лох болсныг илтгэнэ. Нийтлэлийн хувьд үнэхээр сонирхолтой, уншууртай, сэтгэгдэл төрүүлэм болсныг энд зориуд дурдъя. Гагцхүү ур чадвартай, олонд танигдан таашаагдсан залуу сэтгүүлч нэг сэдвийнхээ “золиос” болох вий гэсэн үүднээс тэмдэглэв.

Ерөнхийлөн дүгнэж хэлбэл; Үндэсний тэргүүлэгч GoGo.mn сайт нь мэдээллийн технологи, интернет сэтгүүл зүйн эрин үед Монголын хэвлэл мэдээллийн салбарт түүчээ нь болж, мультимедиа сэтгүүл зүйг төлөвшүүлэн, манлайлж байгаа билээ. Редакцийн бодлого, чадварлаг сэтгүүлчдийн баг, олон нийтийг татсан хүртээмж, нөлөөлөл, уншигчдийн итгэл үнэмшил, хандлага, энэ бүхнийг баталгаажуулан хөгжүүлэгч, илэрхийлэгч нь сэтгүүлчийн бүтээл байдаг. Энэ утгаараа GoGo.mn-ы нүүр царай болж, олон цуврал нийтлэл, сонирхолтой ярилцлагуудаараа уншигчдад танигдсан сэтгүүлч бол Г.Одгарав юм. Түүнийг мэргэжлийн хүрээнд ч өндрөөр үнэлж буй бөгөөд Оны шилдэг сэтгүүлчээр удаа дараа нэрлэгдсэн нь үүний баталгаа юм. Би ч хувьдаа энэхүү шүүмжийг бичих зуур тэдний эгнээнд нэгдэж байна.

Г.Одгарав нь үнэхээр нөр их хөдөлмөр гарган нийгмийн сайн сайхан, тодорхой бүлэг иргэдийн эрх ашгийн төлөө тууштай хөдөлмөрлөж, сэтгүүлч хүний нийгмийн үүрэг, хариуцлагаа ухамсарлан хэрэгжүүлсэн

том жишээ болж буйг онцлон тэмдэглэе.

Мэдээллийн эх сурвалж, баримт ашиглах чадвар, сэтгүүлчийн хөдөлмөрч чанар, сайн хэл найруулга, сонирхолтой гарчиг, мультимедиа хэрэгслээр дамжуулан агуулгаа баяжуулах туршлага... Энэ бүхэн сэтгүүлч Г.Одгаравын бүтээлээс харагдлаа.

Ишлэл

1. <http://news.gogo.mn/r/180868>
2. <http://news.gogo.mn/r/170093>
3. <http://news.gogo.mn/r/172892>
4. <http://news.gogo.mn/r/180196>
5. <http://news.gogo.mn/r/180196>
6. <http://news.gogo.mn/r/180868>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Зулькафиль М.* 2009. Сэтгүүлчийн ур чадвар II. УБ

2. *Чойсамба Ч.* 2016. Сэтгүүлчийн ёс зүйн тухай өгүүллүүд. УБ

3. *Болд-Эрдэнэ Б.* 2012. Интернет сэтгүүл зүй. УБ.

Резюме

Автор данной статьи пишет рецензию на серию корреспонденции журналистки информационного портала GoGo.mn, Г.Одгарав, которая посвящена теме о центральной системе очистки воды в г.Улан – Батор, и тем самым затрагивает экологические вопросы реки Тула и столицы. Корреспонденция журналистки Г.Одгарава послужила хорошим примером социальной ответственности в монгольских СМИ, в частности в портале GoGo.mn. Автор уделяет большое внимание профессиональному анализу корреспонденции, журналистскому мастерству Г.Одгарав и информационному эффекту данной корреспонденции для общественности и властных структур Монголии.